



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/339

Есөнбулаг

Комисс томилох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм шинэчлэн батлах тухай" 212 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны "Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм батлах тухай" 211 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Есөнбулаг сумын Жинст багийн нутаг дэвсгэрт иргэн Д.Цогбаярын захиалгаар баригдсан 13 айлын үйлчилгээтэй орон сууцны барилгыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Б.Бямбадорж	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд аймгийн ерөнхий архитектор)
Гишүүдэд:	М.Мандахүү	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн дарга)
	Б.Батбилэг	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын техникийн хяналтын улсын байцаагч)
	С.Энхбаяр	(Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахмад)
	Б.Цэрэндаваа	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын хяналтын инженер)
	Ш.Ариунаа	(Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үндэсний холбооны аймгийн зөвлөл)
	Д.Байгальмаа	("Ундарга-Алтай" аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын ерөнхий инженерийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
	Д.Баярчулуун	("Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК-ийн ерөнхий

- инженер)
- Д.Цэвэлмаа ("Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨХК-ийн ерөнхий инженер)
- С.Дарамдад ("Мандал голомт" ХХК-ийн гүйцэтгэх захирал)
- Ч.Нарандэлгэр ("Барилга байгууламж" ХХК-ийн захирал) (Зохиогч)
- Н.Өлзийсайхан ("Сутайн хөх уулс" ХХК-ийн инженер) (гүйцэтгэгч)
- Д.Ариунтуяа (Мобиком корпорацийн салбарын захирал) (ашиглагчийн төлөөлөл)
- Нарийн бичгийн дарга: Д.Цогбаяр (Есөнбулаг сумын иргэн) (захиалагч)

2.Барилга байгууламжийн угсралтын ажлыг байнгын ашиглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсан техникийн нөхцөл, зураг төсөл, холбогдох баримт бичгийн бүрдэлтэй нийцүүлэн хүлээн авч, үр дүнг 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн дотор танилцуулахыг комисс (Б.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ  Г.ЧИНБАТ

